

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Шаравын Чойдог	Дугаар	L105
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Мөрөн сум
Төрсөн газар	Мөрөн сумын	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Номтын шүтээн	Сүм хийдийн дугаар	ХЭМР 065
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Мөрөн сумын Номтын шүтээн

-Номтын шүтээн хэдэн ламтай, ямар ямар хурал хурдаг газар байсан бэ?

Ер нь 30 гаран ламтай цагийн хурал ерөөл хурдаг байсан даа. 2 унзад 2 гэсгүйтэй тийм л хийд байсан даа.

-Хэр олон дугантай байсан бэ?

Том гэр дуган байсан. Өвөл цагт шүтээнийхээ байшин дотор зуух тавиад хурдаг байсан. Цагаан сараас эхлээд битүүн 9 битүүнээс эхлээд 15 хүртэл хурдаг байсан.

-29-нөөс өмнө Хуучин хурал хурж байсан уу?

15-д хүртэл ерөөл хураад тардаг байсан.

-Хэдэн онд байгуулагдсан хийд байсан бэ?

Мэдэхгүй. Би 8 настай сахил хүртээд сууж байсан. 1928 онд цэрэгт явсан. Эргээд ирэхэд байхгүй болсон байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Таны сууж байх үеийн их лам, мяндагтан, унзад, гэсгүй нарынх нь нэрийг хэлж өгөөч?

Хамба нь Чойжамц гэдэг юм. Миний багш. Татагдаад явсан. Тэгээд байхгүй. Унзад нь Гэндэндаржаа гэж багшийн дүү байсан. Зундуй гэж байсан. Хоёр гэсгүй байсан. Төмөр гэлэн гэж байсан. Халзан гэсгүй гэж нэг өвгөн байсан. Сайхан лам байсан.

-Цагийн хуралтай газар байсан уу?

Зун нэг хэд хоног зун цагаан идээтэй үед хурдаг байсан. Өвөл бол хэдхэн хоног хурдаг байсан. Олон гэлэн байгаагүй. Хайлан энэ тэр гэж байгаагүй.

-Өвөл 15-ны ерөөлөөс өөр ямар хурал хурдаг байсан юм?

Хамжилганы бурхан суурин гэж байсан. Тойдууд отог гэж байсан. Тэрний хоёр тэрний 2 шүтээн байсан. Энэ Мөрөнд. Ердөө Мөрөнгийн Эх Өлзийтийн арханд байсан.

-Майдар эргэж, Ганжуур хурдаг байсан уу?

Майдар эргэхгүй. Ганжуур, Данжуур судар энэ тэр хурдаг байсан.

-Өөр онцлох хурал юу байв? Цам гарч байсан уу?

Үгүй.

-Ямар шүтээнтэй байсан юм бэ?

Гол нь Гомбо шүтээнтэй байсан даа.

-Хэдэн дацантай байсан бэ? Өөр тусдаа Чойр энэ тэр байсан уу?

Байгаагүй ээ.

-Хийдийн жасын талаар ярьж өгөхгүй юу. Ямар айл дээр байсан бас хэр их байсан?

Хөхсүм, Гана гэж 2 хүн малыг нь малладаг байсан. Тэднийхээс үлдсэн юм байхгүй.

-Хэр олон малтай ямархуу сан хөмрөгтэй байсан юм бэ?

Ямар ч байсан адуутай байсан. Тэр болгоныг сайн мэдэхгүй.

-Номтын хурал хэдэн онд хаагдсан юм?

Суурь нь энэ хойно бий л дээ. 1937 онд тарсан шүү дээ.

-Та энэ Мөрөн суманд харъяалагдах бусад хурлын газруудын тухай энэ Гүний шүтээн энэ тэрийн талаар ярьж өгөөч?

Нэг дугантай л байсан. Зуны хурлаар л нэг явж орж байсан тэнд сууж байгаагүй. Эдний эцэг унзад нь байсан. Ёндон гэж хүн. Олон ламтай байсан. Суварганы хийд гэж Өндөрхаан дээр Майдар энэ тэр эргэдэг байсан. Тэндээ зуны хурлыг олон лам нар хурдаг юм байна лээ. Олон ламтай байсан. 2,3 дугантай. Газар нь айхтар хадан болохоор тарчихсан юм. Хайдав нэг муухан мэдэх байх даа. Гүний шүтээнийг би мэдэх ч үгүй. Суурийг нь л мэднэ.

-Гүний шүтээнийг явуулын журмаар Улаан юм хурж байсан гэж манай аав хэлж байсан? (хамт яваа нутгийн хүн)

Мэдэхгүй.

-Энэ Хөндлөнгийн шүтээн гэж хаана байсан юм бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цагаан толгойн ард нэг суурины чулуу байдаг юм даа. Тэрнийг сайн мэдэхгүй. Цоохор Шарав гуайн хөгшиний ах гэсгүй нь байсан юм гэнэ лээ. Цэвээнийн Шаравжамц гэж өвгөн лам байсан юм гэнэ лээ. Тэр л гэсгүй нь байсан гэсэн.

-Жаргалтхааны баруун хойно Дэчин хавьцаа нэг хурал байсан байх юм?

Жаргалтхааны Баатарын дацан гэж байсан. Тэрийг бол би сайн мэдэхгүй. Баатарын дацан гэж аргагүй хэдэн байшин байдаг байсан. Хийд байхыг нь мэдэхгүй. Энэ Бүстэд бас нэг хийдийн суурь байдаг юм.

-Замбилан хийд гэж хаана байсан юм бол? Мөрөнгөөс баруун урагш Нарийн овоо гэдэг газар байсан гэж байгаа?

Мэдэхгүй. Дуулаагүй юм байна. Манай суманд тийм газар байдаг юмуу? Шавь нарын хийд гэж байсан байх. Номтын шүтээн, Бурхан суурин энэ хоёрыг л мэднэ дээ. Дандаа шавь нар л байсан гэнэ лээ дээ.

-Замбалин хийд гэж та сонссон уу? Жаргалтхаан, Мөрөн хоёрын дунд байсан?

Манай энэ хавьд байгаагүй байхаа.

-Гичгинээс хойшоо Дашбалжир Улаан худаг гэдэг газар тэнд хийд байсан уу?

Дэлгэр овоонд Тахилтын хийд гэж байсан.

-Тэрнээс урагшаадуу хийд байсан уу?

Мэдэхгүй. Цэнхэрт нэг Согтуугийн хийд гэж байсан. Би нэг багштайгаа хотоор яваад дайраад. Том том ваартай тогооны нэрмэлтэй том том царай нь улайсан лам нар байсан.

-Согтуугийн хийд хэдэн дугантай байсан бэ?

2,3 дугантай байсан. Би дайраад л өнгөрч байсан даа. Зунд л хурал хурдаг газар байсан даа.